УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/179/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батсайхан<br>Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт........................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................

3. Аудитын тайлан ........................................ 7

   3.1 Ерөнхий зүйл ........................................ 15

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........................................ 15

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 16

   3.4 Материаллаг байдал........................................ 16

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 16

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 16

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 18

   3.8 Аудитын гол асуудал........................................ 18

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 18

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................ 19

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 19

4. Аудитын илрүүлэлт........................................ 19

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.БУРМАА ТАНАА

2022.02.25 № УВА-2022/179/НА-СТА-ТМ3
танай ____________-ны № ______________-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200328

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,214,243.61** | **65,821,498.09** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 5,927,713.11 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 5,927,713.11 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 5,927,713.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 5,927,625.41 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 87.70 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 17,523,800.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 17,523,800.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 19,214,243.61 | 42,369,984.98 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,336,646.00 | 17,488,645.50 |
| 35130 | Эм боох материал | 3,336,646.00 | 17,488,645.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,877,597.61 | 24,881,339.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,634,300.00 | 1,499,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,758,897.60 | 19,008,639.47 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 190,000.00 | 600,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 294,400.01 | 3,773,400.01 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **284,795,328.44** | **1,333,298,607.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 284,795,328.44 | 1,333,298,607.79 |
| **392** | **Биет хөрөнгө** | 268,327,328.44 | 1,316,830,607.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 132,146,520.00 | 1,130,335,809.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -12,266,448.72 | -18,399,673.08 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 66,131,833.00 | 125,531,833.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -34,844,350.40 | -44,471,833.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 29,318,291.00 | 39,536,869.09 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20,892,410.10 | -16,179,783.49 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,464,713.00 | 19,539,713.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,932,954.27 | -7,979,633.64 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 144,048,797.00 | 153,186,079.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -46,846,662.07 | -64,268,772.09 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,468,000.00 | 16,468,000.00 |
| 39301 | Програм хангамж | 440,000.00 | 440,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -440,000.00 | -440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,468,000.00 | 16,468,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **304,009,572.05** | **1,399,120,105.88** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **304,009,572.05** | **1,399,120,105.88** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 304,009,572.05 | 1,399,120,105.88 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 234,693,025.00 | 234,693,025.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 234,693,025.00 | 234,693,025.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 44,762,826.41 | 1,139,873,360.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 44,762,826.41 | 44,762,826.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,095,110,533.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 24,553,720.64 | 24,553,720.64 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **304,009,572.05** | **1,399,120,105.88** |

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **444,219,812.00** | **1,770,263,841.46** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,742,796.00** | **1,114,858,171.46** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 5,742,796.00 | 1,114,858,171.46 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,742,796.00 | 1,114,858,171.46 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,742,796.00 | 1,114,858,171.46 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **80,102,516.00** | **221,387,770.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 358,374,500.00 | 434,017,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,844,536.00 | 120,648,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 11,860,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,457,836.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,386,700.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 108,788,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,441,800.00 | 62,692,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,441,800.00 | 62,692,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 20,816,180.00 | 38,047,370.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,816,180.00 | 38,047,370.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **486,144,716.16** | **675,153,307.63** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **486,144,716.16** | **675,153,307.63** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 485,051,247.16 | 633,856,625.63 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 293,269,572.00 | 326,544,647.72 |
| 210101 | Үндсэн цалин | 263,945,349.00 | 281,339,213.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,679,422.00 | 4,690,999.80 |
| 210104 | Урамшуулал | 18,604,801.00 | 35,474,434.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,063,688.00 | 41,690,694.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,084,729.00 | 30,095,050.68 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,892,663.00 | 3,237,624.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,300,669.00 | 2,559,859.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,740.00 | 527,105.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,325,887.00 | 5,271,054.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,602,815.00 | 60,881,018.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,650,085.00 | 3,555,834.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,767,730.00 | 57,005,184.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 185,000.00 | 320,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,112,050.00 | 43,779,266.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,599,000.00 | 2,267,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,268,550.00 | 33,464,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,950,000.00 | 1,949,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 999,500.00 | 3,119,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,295,000.00 | 2,978,186.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,955,232.00 | 107,854,712.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,864,907.00 | 99,868,167.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,605,325.00 | 6,856,545.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,485,000.00 | 1,130,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,099,200.00 | 1,689,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 499,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,599,200.00 | 1,190,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,147,000.00 | 1,124,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,147,000.00 | 1,124,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,048,154.00 | 956,332.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 200,000.00 | 61,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,600.00 | 110,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 54,554.00 | 47,510.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 23,350.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 432,000.00 | 432,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,000.00 | 65,872.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,753,536.16 | 49,336,455.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,913,386.00 | 4,081,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 45,840,150.16 | 45,255,055.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,093,469.00 | 41,296,682.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 41,085,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 41,085,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,093,469.00 | 211,182.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,093,469.00 | 211,182.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-41,924,904.16** | **1,095,110,533.83** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-41,924,904.16** | **1,095,110,533.83** |

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **438,477,016.00** | **637,881,870.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,477,016.00** | **637,881,870.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 358,374,500.00 | 434,017,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,844,536.00 | 120,648,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 11,860,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,457,836.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,386,700.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 108,788,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,441,800.00 | 62,692,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,441,800.00 | 62,692,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 20,816,180.00 | 20,523,570.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,816,180.00 | 20,523,570.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **438,477,016.00** | **631,954,156.89** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **438,477,016.00** | **631,954,156.89** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **437,383,547.00** | **590,657,474.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 293,269,572.00 | 326,544,647.72 |
| 210101 | Үндсэн цалин | 263,945,349.00 | 281,339,213.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,679,422.00 | 4,690,999.80 |
| 210104 | Урамшуулал | 18,604,801.00 | 35,474,434.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,063,688.00 | 41,690,694.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,084,729.00 | 30,095,050.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,892,663.00 | 3,237,624.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,300,669.00 | 2,559,859.29 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,740.00 | 527,105.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,325,887.00 | 5,271,054.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,602,815.00 | 60,881,018.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,650,085.00 | 3,555,834.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,767,730.00 | 57,005,184.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 185,000.00 | 320,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,724,550.00 | 43,423,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,207,000.00 | 1,609,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,268,550.00 | 33,464,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,950,000.00 | 1,949,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 999,500.00 | 3,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,199,500.00 | 3,100,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,858,482.00 | 105,042,703.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,458,757.00 | 92,444,658.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,899,725.00 | 8,098,045.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 4,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,099,200.00 | 6,529,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,430,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 499,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,599,200.00 | 1,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,147,000.00 | 1,124,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,147,000.00 | 1,124,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,312,854.00 | 956,332.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 464,700.00 | 61,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,600.00 | 110,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 54,554.00 | 47,510.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 23,350.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 432,000.00 | 432,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,000.00 | 65,872.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,305,386.00 | 4,464,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,305,386.00 | 4,464,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,093,469.00** | **41,296,682.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 41,085,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 41,085,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,093,469.00 | 211,182.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,093,469.00 | 211,182.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **5,927,713.11** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 5,927,713.11 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 5,927,713.11 |

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **44,762,826.41** | 304,009,572.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **44,762,826.41** | 304,009,572.05 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **44,762,826.41** | 304,009,572.05 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **44,762,826.41** | 304,009,572.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **44,762,826.41** | 304,009,572.05 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,095,110,533.83 | 1,095,110,533.83 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **234,693,025.00** | **24,553,720.64** | **1,139,873,360.24** | 1,399,120,105.88 |

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 517,427,000.00 | 511,094,862.59 | 6,332,137.41 | 98.78 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 517,427,000.00 | 511,094,862.59 | 6,332,137.41 | 98.78 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 517,427,000.00 | 511,094,862.59 | 6,332,137.41 | 98.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 320,707,500.00 | 317,629,247.72 | 3,078,252.28 | 99.04 |
| 210101 | Үндсэн цалин | 281,923,600.00 | 281,339,213.92 | 584,386.08 | 99.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000.00 | 4,690,999.80 | 1,117,000.20 | 80.77 |
| 210104 | Урамшуулал | 27,935,900.00 | 26,559,034.00 | 1,376,866.00 | 95.07 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 | 00.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,295,500.00 | 40,789,361.87 | 2,506,138.13 | 94.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,467,200.00 | 29,193,718.38 | 1,273,481.62 | 95.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,207,100.00 | 3,237,624.34 | -30,524.34 | 100.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,565,600.00 | 2,559,859.29 | 5,740.71 | 99.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 641,400.00 | 527,105.56 | 114,294.44 | 82.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,414,200.00 | 5,271,054.30 | 1,143,145.70 | 82.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,092,200.00 | 60,881,018.00 | 211,182.00 | 99.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,625,000.00 | 3,555,834.00 | 69,166.00 | 98.09 |
| 210302 | Түлш, халаалт | 57,147,200.00 | 57,005,184.00 | 142,016.00 | 99.75 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 320,000.00 | 320,000.00 | 00.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,268,300.00 | 38,267,400.00 | 900.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,609,900.00 | 1,609,800.00 | 100.00 | 99.99 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,308,400.00 | 28,308,400.00 | 00.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,950,000.00 | 1,949,200.00 | 800.00 | 99.96 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 100,000.00 | 00.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,200,000.00 | 3,200,000.00 | 00.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,100,000.00 | 3,100,000.00 | 00.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,457,000.00 | 40,453,203.00 | 3,797.00 | 99.99 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,857,000.00 | 27,855,158.00 | 1,842.00 | 99.99 |
| 210502 | Хоол, хүнс | 8,100,000.00 | 8,098,045.00 | 1,955.00 | 99.98 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,500,000.00 | 4,500,000.00 | 00.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,600,000.00 | 6,529,500.00 | 70,500.00 | 98.93 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 | 4,430,000.00 | 70,000.00 | 98.44 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 499,500.00 | 500.00 | 99.90 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 1,600,000.00 | 00.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,150,000.00 | 1,124,000.00 | 26,000.00 | 97.74 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,150,000.00 | 1,124,000.00 | 26,000.00 | 97.74 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,390,000.00 | 956,332.00 | 433,668.00 | 68.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 61,000.00 | 239,000.00 | 20.33 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 216,000.00 | 144,000.00 | 60.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,600.00 | 110,600.00 | 00.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 56,000.00 | 47,510.00 | 8,490.00 | 84.84 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 23,350.00 | 31,650.00 | 42.45 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 432,000.00 | 432,000.00 | 00.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,400.00 | 65,872.00 | 10,528.00 | 86.22 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4466500.00 | 4464800.00 | 1,700.00 | 99.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,466,500.00 | 4,464,800.00 | 1,700.00 | 99.96 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 517,427,000.00 | 517,022,488.00 | 404,512.00 | 99.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 434,017,900.00 | 434,017,900.00 | 00.00 | 100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 434,017,900.00 | 434,017,900.00 | 00.00 | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 62,692,200.00 | 62,481,018.00 | 211,182.00 | 99.66 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 62,692,200.00 | 62,481,018.00 | 211,182.00 | 99.66 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 20,716,900.00 | 20,523,570.00 | 193,330.00 | 99.07 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,716,900.00 | 20,523,570.00 | 193,330.00 | 99.07 |

### 2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **120,648,112.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **120,648,112.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 79,562,612.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 8,915,400.00 |
| 210104 | Урамшуулал | | 8,915,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 901,332.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 901,332.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 5,156,380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 5,156,380.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 64,589,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 64,589,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 41085500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 41,085,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 41,085,500.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 120648200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 120,648,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 11,860,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 108,788,200.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь “Иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэвшүүлэх замаар эрүүл мэндийн байдалд чанарын ахиц гаргаж,сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн төвийг хөгжүүлж бэлхжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 675,153.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13,503.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,800.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,095,110.5 мянган төгрөгөөр буюу 78 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 5,927.7 | 5,927.7 |
| Авлага | 0.0 | 17,523.8 | 17,523.8 |
| Бараа материал | 19,214.2 | 42,370.0 | 23,155.8 |
| Үндсэн хөрөнгө | 284,795.3 | 1,333,298.6 | 1,048,503.3 |
| **Нийт хөрөнгө** | 304,009.6 | 1,399,120.1 | 1,095,110.5 |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 304,009.6 | 1,399,120.1 | 1,095,110.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 304,009.6 | 1,399,120.1 | 1,095,110.5 |

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, эцэст 5,927.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,370.0 мянган төгрөг болж 23,155.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан эм боох материал, хүнсний материал, аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,333,298.6 мянган төгрөг болж 1,048,503.3 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 998,189.3 мянган төгрөгийн Эрүүл мэндийн төвийн өртгөл баригдаж ашиглалтад орсноос, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 4430.0 мянган төгрөгөөр тоног, төхөөрөмж худалдан авсан, 1,089,328.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн, 15,738.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, устгасантай холбоотойгоор буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,399,120.1 мянган төгрөг болж 1,095,110.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,326,044.0мянган төгрөгөөр буюу 74.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал хандиваар авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 189,008.6 мянган төгрөгөөр буюу 28 хувиар өссөн байна. Энэ нь түлш халаалт, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлууд байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 674,923.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 674,923.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 157,496.1 мянган төгрөгөөр бууруулж 517,427.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 517,427.0 мянган төгрөгийн төсөв батлаcнаас 434,017.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 62,692.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 20,716.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 434,017.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 62,481.0 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 20,523.9.0 мянган төгрөг, нийт 517,022.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 511,094.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517,094.9 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 11,860.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 108,788.2 мянга, нийт 120,648.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урамшуулалд 8,915.4 мянга, тээвэр шатахууны зардалд 901.3 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 64,589.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 41,085.5.0 мянга, нийт 120,648.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дугаар тушаалаар олгосон урамшуулалтай давхардуулан ажилтнуудад 10,000.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

*Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 64/А/268 дугаар тушаалын 3.7 “Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох шууд бус зардал багтана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв | 1 | 10,000.0 | | | | | | | 1 | 10,000.0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2022 оны 02 сарын 25-ны өдөр